



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2021 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 3/02

Эмээлтолгой

Г Малын тоо толгойн албан татварын  
хувь хэмжээг тогтоох тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "Д", Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3 дахь заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Малын тоо толгойн албан татварын хэмжээг нэгдүгээр хавсралтаар, малчны амьжиргааг дэмжих зорилгоор албан татвараас чөлөөлөх малын тоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сумын хэмжээнд өвөлжилт хүндэрсэн, нийт нутгаар гантай байгаа тул малчдын амьжиргааг дэмжих зорилгоор 2021 оны малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг "0" төгрөгөөр тогтоосугай.

3. Малын тоо толгойн албан татварыг хуульд заасан хугацаанд орон нутгийн төсөвт төвлөрүүлж, Төвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д заасан үйл ажиллагаанд зарцуулан удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын Засаг дарга /Д.Мөнхжаргал/-д даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулж сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 2/11 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  П.БАЯРСАЙХАН

1518081

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны  
07 дугаар сарын 09-ны өдрийн ээлжит III хуралдааны  
3/02 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ

Д/д	Малын төрөл	Нэг толгой малд ногдох албан татварын хувь хэмжээ /төгрөг/
1	Адуу	1000
2	Үхэр	1000
3	Тэмээ	0
4	Хонь	300
5	Ямаа	700

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны  
07 дугаар сарын 09-ны өдрийн ээлжит III хуралдааны  
3/02 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

МАЛЧНЫ АМЬЖИРГААГ ДЭМЖИХ ЗОРИЛГООР  
АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ МАЛЫН ТОО

Д/д	Малын төрөл	Малчин, мал бүхий өрхийн 1 гишүүн тутамд албан татвараас чөлөөлөгдөх малын тоо
1	Адуу	5
2	Үхэр	5
3	Хонь	10
4	Ямаа	8

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_